

ЦЭРГИЙН УДИРДЛАГЫН ЗАРИМ АСУУДАЛ

А.Амгаланбаяр

ДХИС-ийн Удирдлагын академийн Хилийн албаны удирдлага, стратегийн тэнхимийн ахлах багш, дэд хурандаа

Товч агуулга: Цэргийн удирдлага бол үр дүнтэй цэргийн үйл ажиллагаа явуулахад зайлшгүй чухал хүчин зүйл бөгөөд төрийн удирдлагын онцгой төрөл юм. Үүнд цэргийн алба хаагчдыг удирдан чиглүүлэх, цэргийн хүчнийг зохион байгуулах, стратеги төлөвлөх, дайныг удирдах зэрэг олон чухал үүрэг хамаардаг тул юуны өмнө Цэргийн удирдлагын тухай ойлголт, хөгжил, судлах зүйлийн талаар ойлгуулахыг зорив.

Abstract: Military leadership is an essential factor in effective military operations and is a special type of government. It includes many important functions such as leading military personnel, organizing military forces, planning strategies, and managing war, so first of all, it is intended to make people understand the concept, development, and study of military leadership.

Түлхүүр үг: Удирдлага, Судлах зүйл, Зорилго, Зарчим

Keywords: Management, Study, Objectives, Principles

ОРШИЛ

Цэргийн удирдлага бол үр дүнтэй цэргийн үйл ажиллагаа явуулахад зайлшгүй чухал хүчин зүйл бөгөөд төрийн удирдлагын онцгой төрөл юм. Үүнд цэргийн алба хаагчдыг удирдан чиглүүлэх, цэргийн хүчнийг зохион байгуулах, стратеги төлөвлөх, дайныг удирдах зэрэг олон чухал үүрэг хамаардаг.

"Цэргийн удирдлага" гэдэг ойлголт шинжлэх ухаанд эртнээс хэрэглэгдэж, XIX зууны сүүлчээр "Цэргийн ба тэнгисийн шинжлэх ухааны тайлбар толь"-д удирдлагын тухай анхны тайлбарыг хийж, "Цэргийн удирдлага гэдэг нь олон тооны янз бүрийн салбарыг нэгтгэн захирахаар байгуулагдсан тусгай байгууллага" гэж тодорхойлсон байна.

Энэ нэр томьёо нь "Батлан хамгаалах тухай хууль", "Дайны

байдлын тухай хууль", Цэргийн номлол зэрэг албан ёсны баримт бичгүүдэд хэрэглэгдэж байна. Үнэн хэрэг дээрээ энэ нь "Төр, засгийн болон цэргийн удирдлагын байгууллагууд"-ын тухай, өөрөөр хэлбэл Зэвсэгт хүчин, бусад цэрэг, цэргийн байгууллагуудыг удирдах хууль журмын талаар яригдаж байгаа юм. Одоохондоо "Цэргийн удирдлага" гэдэг нэр томьёог бүх талаас нь бүрэн тодорхойлсон тодорхойлолт байхгүй байна. Шинжлэх ухааны ном, зохиолуудад "Цэргийг удирдах" гэдэг ойлголтыг "Цэргийн удирдлага" гэдэгтэй адилтган тайлбарлаж байгаа нь бүрэн оновчтой бус бөгөөд "Цэргийн удирдлага" гэдэг ойлголт нь нэлээд өргөн ойлголт юм.

НЭГ. ЦЭРГИЙН УДИРДЛАГЫН ОНОЛЫН ҮНДЭС

Шинжлэх ухаанд ерөнхий асуудлаас тодорхой руу шилжин судлах арга зүй байдаг. Энэ нь тухайн тодорхой асуудалд хандахдаа ерөнхий асуудлаа эхнээс нь зөв ойлгож, нэгдсэн тодорхой ойлголттой болох зайлшгүй шаардлагатай байдагтай холбоотой.

Энэ үүднээс цэргийн удирдлагын тухай асуудлыг авч үзэхдээ эхлээд удирдлагын ерөнхий онолын тухай ойлголт, түүний мөн чанар, агуулга нийтлэг хуулиуд зэрэг үндсэн асуудлуудад нь анхаарлаа хандуулах нь зүйтэй юм.

Удирдлага гэдэг ойлголт нь тодорхой олон тооны бүрэлдэхүүн хэсгүүдийн харилцан ажиллагааг буюу хүрээлэн буй орчин, нийгэм, хувь хүмүүсийн үйл ажиллагааг журамтай /цэгцтэй/ болгох шинж чанарыг агуулсан уламжлалт ойлголт болж хөгжсөн байна.

Хуулийн шинжлэх ухаан нь удирдлага бол үйл ажиллагааны шинж чанартай, удирдлага нь хүний хөдөлмөрийн онцгой төрлөөс бүрддэг гэж үздэг. Энэ үйл ажиллагаа нь хуулиудыг биелүүлэх эрх зүйн баримт бичгүүдийг боловсруулах тэдгээрийг хэрэгжүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг явуулах зэрэг захиргааны шинж чанартай ажиллагаагаар явагдана гэж үздэг.

Энэ бүгдээс үзэхэд **“Удирдлага”** гэдэг нэр томьёо нь хүмүүс объектууд болон ажиллагааны үйл явцад зориудаар, зорилго-чиглэлтэй нөлөөлж байгаа хүний үйл ажиллагааны нэг төрлийг илэрхийлнэ. Удирдлага гэдгийн мөн чанар нь "нөлөөлөг" гэдэг ойлголтын тусламжтайгаар илэрч байгаа бөгөөд удирдлагад хамгийн гол нь-хүмүүсийн ухамсар, зан авир, үйл ажиллагаанд нөлөөлөх агшин /мөч/ байдаг.

Удирдлага нь нэлээд тооны хүмүүсийн үйл ажиллагааг зохицуулах

болон хуваарилах шаардлага гарсан тохиолдолд зайлшгүй хэрэгтэй болдог.

УДИРДЛАГЫН МӨН ЧАНАР, АГУУЛГА, ЕРӨНХИЙ ХУУЛИУД

Үе үеийн эрдэмтдийн хийсэн судалгаа шинжилгээний ажлын үр дүнд удирдлага, зохицуулалтын үйл ажиллагаатай холбоотой олон нээлт гарч байсан бөгөөд нэн ялангуяа ХХ зууны эхэн хагасын техникийн хөгжлийн түвшин, түүний дотроос удирдлага, холбооны техникийн хөгжлийн шинэ эрин үе нь үүнд ихээхэн нөлөө үзүүлжээ.

Эрдэмтэн Норберт Винер, түүний хамтран зүтгэгчдийн удирдлага, зохицуулалтын үйл ажиллагааны ерөнхий хууль, зүйн тогтлыг нээн илрүүлэх чиглэлтэй судалгааны ажлын онолын гол цөм нь амьд организм, автомат төхөөрөмж зэрэг удирдлага, зохицуулалттай систем бөгөөд тэр нь гадаад орчны хувьсах нөлөөллийг мэдэрч, хүлээн авах чадвартай, өөрөө өөрийгөө зохицуулах үйл ажиллагаагаараа эргээд гадаад орчиндоо идэвхтэй нөлөө үзүүлдэг систем болох тухай тодорхойлолт юм.

Шинжлэх ухаанд удирдлагыг үйл ажиллагаа явагдах орчин нөхцөлөөр нь дараах гурван төрөлд хуваан үздэг.

1. Амьгүй байгаль дахь удирдлага, түүний дотор машин, техникийн удирдлага,

2. Амьд байгалийн буюу биологийн удирдлага,

3. Хүний нийгмийн удирдлага

Эрдэмтэд амьгүй байгаль, амьд организм, автомат төхөөрөмжийн удирдлага, зохицуулалтын үйл ажиллагааны ерөнхий хууль, зүй тогтлуудыг нээн илрүүлсэн бөгөөд тэдгээр нь нийгмийн хүрээний удирдлагын үйл ажиллагаанд ч нийтлэг үйлчилдэг болохыг тогтоожээ.

Нийгмийн хүрээний хувьд удирдлага гэдэг нь нийгмийн үйл ажиллагааны функц, түүний бүрэлдэхүүн хэсэг бөгөөд нийгмийн амьдрал, хөдөлмөрийн явцад хүмүүсийн хамтын үйл ажиллагааг нь зохицуулах шаардлагын үүднээс урган гарсан ухагдахуун юм.

Нийгмийн амьдрал нь материйн оршин байх нэг хэлбэр учраас нийгмийн амьдралд болж байгаа ихэнх үзэгдэл тэдгээрийн зүй тогтлууд нь материйн орших бусад хэлбэр, тухайлбал биологи, физик, механик зэрэг хөдөлгөөний хэлбэрүүдэд нийтлэг үйлчлэх хууль, зүй тогтолуудад захирагдаж байдаг. Энэ утгаараа нийгмийн хүрээний удирдлагын үйл ажиллагаа нь бас бодит ертөнцийн түгээмэл хуультай байх нь тодорхой юм. Нийгмийн хүрээний удирдлагын тогтолцоо нь амьд организм автомат төхөөрөмжийн нэгэн адил гаднын хувьсах нөлөөллийн дор орших бөгөөд эргээд гадаад орчиндоо идэвхтэй нөлөөлдөг байна. Биологи техникийн болон нийгмийн хүрээний аливаа удирдлага зохицуулалтын үйл ажиллагаанд удирдлагын гол төв байх бөгөөд тэр нь хүн амьтанд уураг тархи, төв мэдрэлийн систем, техникийн системд тооцоолох машин, программ хангамж байдаг бол, нийгмийн хүрээний удирдлагын тогтолцоонд удирдлагын аппарат байдаг.

Цэргийн удирдлагын мөн чанар нь төр, иргэдийн өмнө хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх бэлтгэл, бэлэн байдлыг хангах, хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааг бүх шатны захирагч дарга, штаб, цэргийн удирдлагын бусад байгууллагаас төлөвлөх, зохион байгуулах, зохицуулах, хяналт- шинжилгээ хийж, үнэлгээ өгөхөд оршино.

Цэргийн удирдлагын онолын зорилго нь тавигдсан үүргийг

хэрэгжүүлэхийн төлөө цэргийн нэгтгэл, анги, салбараа дээд зэргээр үр ашигтай ашиглахад шинжлэх ухааны үндсэлэлээр хангахад оршино. Энэ зорилгод хүрэхийн тулд цэргийн удирдлагын байгууллага нь цэргийн удирдлагын агуулгыг илэрхийлэх олон талт үүргийг гүйцэтгэнэ. Эдгээр үүрэгт:

- Бие бүрэлдэхүүнд мэргэжлийн өндөр бэлтгэл, бие бялдар, сэтгэл зүйн хатуужил олгож, үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг хангах

- Тухайн цагийн байдал, түүний цаашидын өрнөлийн талаарх төсөөлөл, мэдээ, мэдээллийг тасралтгүй цутгуулж судлах, энэ үндсэн дээр зорилго, тухайн цаг үеийн зорилтоо тодорхойлох

- Зорилго, зорилтдоо хүрэх аргыг сонгон, шийдвэр гаргах

- Шийдвэрийнхээ хэрэгжилтийг хангах ажиллагааг төлөвлөх

- Захирагдсан цэргийн нэгтгэл, анги, салбарын гүйцэтгэх үүрэг, хамтын болон харилцан ажиллагааны горимыг тодорхойлж, цаг алдалгүй хүргэх

- Тэдгээрийн үүрэг гүйцэтгэх чадавх, боломжийг бүрдүүлэх бүх талын арга хэмжээ авах

- Үүрэг гүйцэтгэх явцад нь үйл ажиллагааг шуурха зохицуулах, дэмжих туслах

- Гүйцэтгэлт нь хяналт – шинжилгээ хийх, үнэлэлт өгөх, дүгнэлт гаргах зэрэг хамаарна.

ЦЭРГИЙН УДИРЛАГЫН ОНОЛЫН АГУУЛГА.

Цэргийг тасралтгүй, шуурхай, үр дүнтэй удирдахын тулд удирдлага оновчтой тогтолцоотой байх, удирдах байгууллагын үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах, удирдлагын орчин цагийн дэвшилтэд аргыг сонгон хэрэглэх шаардлагатай болно.

Цэргийн удирдлагын тогтолцоог хоорондоо зохицсон байгуулат бүхий цэргийн удирдлагын байгууллага, байр, хийгээд цэргийг удирдах холбооны болон мэдээллийн сүлжээний нэгдсэн нэг бүхэл цогц гэж тодорхойлж болно.

Цэргийн удирдлагын онол нь нийгэм,эрх зүй, мэдээлэлжүүлэлтийн шинжлэх ухааны ололтыг ашиглан, цэргийн ухааны обьектив хуулиудын илрэлд тулгуурлан цэргийн удирдлагын зүй тогтлыг тогтоож, цэргийн удирдлагын зарчим, зохион байгуулалт, ажлын дэвшилтэй арга барилыг боловсруулдаг.

Цэргийн удирдлагын онолын агууллага бол цэргийн удирлагын хууль, зүй тогтол, зарчим, цэргийн удирдлагын тогтолцоо, түүний үйл ажиллагааны зохион байгуулалтын хэлбэр, ажлын арга барилыг бүхэлд нь хамаарах болж байна. Тэгэхдээ байлдаанд цэргийг удирдах, тайван цагт цэргийн удирдлагыг зохион байгуулахаас хамааран цэргийн удирлагын онолын агуулга ялгаатай байх нь мэдээж. Харин цэргийн удирлагын онолын агуулга ялгаатай байх нь мэдээж. Харин цэргийн удирлагын техник, технологийн хангамжийн төвшингөөс цэргийн цэргийн удирдлагын үр дүн илт хамаардаг.

Цэргийн удирдлагын онолын чиг үүрэг

Цэргийн удирлагын онол бусад шинжлэх ухааны онолын нэгэн адил танин мэдэхүйн болон ирээдүйг урьдчилан харах, төсөөлөх чиг үүрэг гүйцэтгэж байна.

Танин мэдэхүйн чиг үүрэг нь цэргийн удирлагын тогтолцооны хоорондоо зохицсон зохион байгуулалт, хэсгүүдийн үндсэн шинж чанар, уялдаа холбоо, зохион байгуулалтын бүтцийн үндэслэл болон удирдлагын онолын агуулгыг

илэрхийлж буй харилцан уялдаа, хамаарал бүхий үүргүүдийн мөн чанар, хууль, зүй тогтол, зарчмыг нээн илэрүүлэхэд чиглэгдэж байна.

Урьдчилан харах төсөөлөх чиг үүрэг нь удирлагын тогтолцоо, удирлагын үйл явц, удирлагын үйл ажиллагааны зохион байгуулалтын хэлбэр, ажлын арга барилын хөгжлийн цаашидын хандлагыг тодорхойлоход оршино. Цэргийн удирлагын онолын урьдчилан харах чиг үүргийг хэрэгжүүлснээр цэргийн удирлагад шинээр гарах үзэгдэл, үйл явц илэрнэ.

Цэргийн удирлагын онолын үндсэн чиг үүрэг нь дэлхийн бүс нутаг, улс оронд гарч буй дайн, зэвсэгт мөргөлдөөн, түүнчлэн цэргийн стратеги, тактикийн хээрийн болон команд-штабын сургууль, дадлагын үеийн цэргийн удирлагын арга, туршлагыг судалж, түүнээс шимэх, удидахуйн ухааны хууль, зүй тогнолыг судлан, цэргийн удирлагад авч хэрэглэх боломжийг нээн, түүнд тулгуурлан цэргийн удирлагын үндсэн зарчмуудад тодотгол оруулж байх, зэвсэглэл, техник, цэргийн холбоо, удирдлагын шинэ техник, технологи, зэвсэгт тэмцлийн арга, тактикийн цаашидын хөгжлийн хандлагыг харгалзан цэргийн удирлагын тогтолцоо, удирдах байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, удирдагчийн ажлын зохион байгуулат, арга барилыг шинэчлэн өөрчлөх санал, зөвлөмж боловсруулах, цэргийн удирлагыг төгөлдөржүүлэх практик зөвлөмжөөр захирагч, штабуудыг хангах зэрэг өргөн хүрээтэй асуудлыг хамарч байдаг.

Цэргийн удирдлагын хууль, зүй тогтол

Цэргийн удирдлагын тогтолцоо, захирагч, штабуудын ажлын зохион байгуулалт, арга барил нь цэргийн удирдлагын хууль, зүй тогтолд хэрхэн

зохицож буйгаас цэргийн удирлагын үйл ажиллагааны үр дүн шууд хамааралтай байдаг байна.

Удирдахуйн ухааны хууль, зүй тогтолын үндсэн дээр цэргийн удирлагын зарчим боловсрогддог бөгөөд энэ удирдамж, дүрэм, зааврын хэлбэрээр илэрхийлэгдэнэ.

Цэргийн шинжлэх ухааны үндэстэй удирдахын тулд удирдахуйн ухааны хууль, зүй тогтолын илрэх хэлбэр, үйлчлэлийг сайн мэдрэх, тэдгээрийг өөртөө зохих хэмжээгээр шингээсэн цэргийн удирдлагын дүрэм, зааврыг амьдрал, үйл ажиллагааныхаа тухайн цагийн байдал, тодорхой нөхцөлд тохируулан зөв аштглах учиртай. Ингэснээр үйл явцын өрнөлийг урьдчилан зөв таамаглах, хэрэгжих үндэстэй зорилт дэвшүүлэх, хамгийн бага зардал /хохирол/-аар зорилгодоо хүрэх оновчтой зөв шийдвэр гаргах, түүнийгээ,

хэрэгжүүлэх таатай нөхцлийг зориудаар бүрдүүлэх, шийдвэрийнхээ гүйцэтгэлийг цаг тухайд нь хянаж зохицуулах нөхцөл бүрдэх болно.

Цэргийн удирдлагын зүй тогтолд нийгмийн харилцаа төрийн байгуулал, тэдгээрт хийцүүлэн тодорхойлогдсон төрийн цэргийн бодлого, зэвсэгт хүчнийг ашиглах номлол, зэвсэгт хүчний эрх зүйн хэм хэмжээг тогтоосон бусад хууль, эрх зүйнактуудаас гадна дайн, зэвсэгт мөргөлдөөний ерөнхий хуулиуд шууд үйлчилж байдаг.

Удирдан зохицуулах үйл ажиллагааны бүтэц

Аливаа тогтолцоог оновчтой зохион байгуулахын үндсэн гол нөхцөл нь зохицуулах тогтолцооны буюу удирдах аппаратын өөрийнх нь бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгож байж сая нийт удирдлагын тогтолцооны зохион байгуулалтыг оновчтой хийх болно.



Удирдан зохицуулах үйл ажиллагааны эдгээр үндсэн хэсгүүд нь оновчтой зохион байгуулалтын хуулийн дагуу бүгд хоорондоо зохицсон байна.

Аливаа тогтолцоонд нөлөөлж байгаа гадны нөлөөлөх хүчин зүйлсийн нөлөөллийг тэр болгон урьдчилан

тооцоолж тодорхойлох боломжгүй буюу тогтолцооны үйл ажиллагааныхаа тухай мэдээлэл нь бүрэн зөв, хугацаандаа ирээгүйгээс тогтолцооны дотор тодорхойгүй байдал үүсдэг байна. Энэхүү тогтолцооны тодорхойгүй байдал нь тогтолцооны тогтвортой шинж

төлөвийг алдагдуулж, ашиглаж буй нөөцөө илүү зарцуулж, ашиггүй ажиллахын үндсэ болдог.

Тодорхойгүй байдлын хэмжээ хичнээн их байх тусам төчнөөн их хэмжээний мэдээлэл шаардлагатай болно. Мэдээлэл авсаны дараа уг мэдээлэл нь алдаагүй бүрэн зөв байвал тогтолцооны төлөв байдал нь тодорхой болж тодорхойгүйн хэмжээ тэгтэй тэнцүү болно. Хэрэв мэдээлэл нь бүрэн биш алдаатай байвал тогтолцооны төлөв байдал нь тодорхой болохгүй.

Удирдлагын шийдвэр гаргах үйл ажиллагаа нь тогтолцоонд нөлөөлж байгаа гадна орчны хувьсах нөлөөллийн хувирч өөрчлөгдөх зүй тогтлын тухай мэдээлэлтэй байж хийгддэг.

Удирдлагын шийдвэр гаргах үйл ажиллагаа нь удирдлагын тогтолцооны зохицуулалтын оновчтой хувилбарыг сонгож хэрэглэхгүй бол ашиглаж буй нөөцөө хэтрүүлэн зарцуулах, нөөц бололцоогоо бүрэн ашиглахгүй байх зэрэг сөрөг үр дагавар гарна.

Удирдлагын шийдвэрийг хэрэгжүүлэхийн тулд удирдах ажилтан, менежер нь удирдлагын тогтолцооны үйл ажиллагаанд нөлөөлөх бүх төрлийн механизмуудын үйл ажиллагаа, хууль, дүрмийг судалж эзэмшсэн, тэдгээрийг тогтолцооны зорилгыг биелүүлэхийн үүднээс бүрэн ажиллауулж ашиглаж чаддаг, тогтолцооны бүх хэсгүүд бүрэн хөдөлж, ажиллаж байх шаардлагатай.

ХОЁР.ЦЭРГИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

Нийгмийн хүрээний аливаа

тогтолцооны оршин тогтнохын гол нөхцөл нь амьд организм, автомат төхөөрөмжийн нэгэн адил гаднын хувьсах нөлөөлөлд өөрийсөө зохицуулж, харьцангуй тогтвортой байдлаа хадгалах чадвартай байхад оршдог.

Удирдлагын тогтолцоо нь бүтцийн хувьд энгийн ба нийлмэл байж болно. Нэг удирдах байгууллагад хэд хэдэн удирдагдах байгууллага харьяалагдаж болох бөгөөд удирдлага нь төвлөрсөн, эсвэл шаталсан байдлаар хэрэгждэг. Төвлөрсөн удирдлагат тогтолцоонд удирдлагын бүх объектуудыг нэг төв байгууллагаас удирдана. Ийм тогтолцооны хувьд мэдээлэл солилцох хурд өндөр байдаг давуу талтай ч удирдлагын төв байгууллагын бүтэц нь нүсэр, мэдээллийг боловсруулах, шийдвэр гаргахад хугацаа их шаарддаг зэрэг хэд хэдэн дутагдалтай. Иймээс олон удирдагдах байгууллага бүхий тогтолцоог шатлан захирагдах зарчмаар байгуулдаг. Энэхүү тогтоцоонд тус бүрдээ улирдах байгууллага, удирдаглах объект бүхий удирдлагын хэд хэдэн түвшин шатлал байдаг. Ийм тогтолцооны доод шатны удирдах байгууллага нь дээд шатныхаа хувьд удирдлагын объект болно. Удирдлагын субьектээр нь дараах зургаан төрөлд хуваадаг. Үүнд:

1. Төсвийн удирдлага. Субъект нь төр.

2. Орон нутгийн өөрийн удирдлага буюу төрийн удирдлагын доод түвшин

3. Менежмент буюу өмч эзэмшигчийн зүгээс өмчөө эрхлэн

явуулах удирдлага

4. Олон нийтийн удирдлага субъект нь хууль тогтоомжоор баталгаажсан институт нийгмийн нэгдэл,

5. Өөрийгөө зохицуулах хамтын удирдлага. Субект нь бусад хүмүүсийн сонирхол нийгмийн байдал, соёлын хэм хэмжээг харгалзан өөрийн бодлоор ажилладаг бүлэг хүмүүс

6. Хувь хүний үйл ажиллагаа

Төрийн удирдлагын нөлөөлөл нь төрийн засаглалд тулгуурлаж баталгаажийн хангагддаг. Энэ үүднээс төрийн удирдлага гэдэг нь өөрийн бүтцийн тогтолцоогоор дамжуулж засаглалын хүчинд тулгуурлан эмх журамтай болгох буюу өөрчлөн байгуулах зорилгоор хүмүүсийн нийгмийн болон хувийн үйл ажиллагаанд төрийн зүгээс үзүүлэх зохион байгуулан зохицуулах нөлөөлөл юм.

Удирдлага, зохицуулалтын үйл ажиллагаа явагдаж байгаа ямар ч

тогтолцоонд нийтлэг үйлчилдэг хууль зүй тогтлууд байдаг.

Эдгээр хууль зүй тогтлууд үйлчилж байгаа нөхцөлд удирдлага зохицуулалтын үйл ажиллагаа явагддаг учраас нийгмийн хүрээнд удирдлагаыг хэрэгжүүлэхдээ түүний ерөнхий хууль, зүй тогтлуудыг судлах нь чухал ач холбогдолтой удирдлагын ерөнхий хууль, зүй тогтлуудыг танин мэдсэнээр удирдлагын шинжлэх ухааны үндэслэлийг дээшлүүлэх, удирдлагыг оновчтой бүтэцтэй, үр ашигтай болгох, удирдлагын үйл ажиллагаанд тооцоолох техник, математик арга, загварчлал хэрэглэх боломжтой болно. Удирдлагын тогтолцоонд түгээмэл үйлчилдэг 3 ерөнхий хууль байдаг.

Энэ нь:

1.буцах холбооны хууль

2. Нөөцийн хууль

3. Оновчтой зохион

байгуулалтын хууль юм.

Цэргийн удирдлагын тогтолцоог дараах байдлаар ангилна.Үүнд:



**ГУРАВ: ЦЭРГИЙН
УДИРДЛАГЫН ЗАРЧИМ**

Удирдлагын зарчим гэдэг нь удирдлагыг зохион байгуулах болон удирдах үйл ажиллагааг хэрэгжүүлэх

үед удирдлагын субъектээс баримтлах ёстой үндсэн дүрэм юм.

Удирдлагын зарчим нь онол, практик хоёрыг холбогч нь байж, удирдлагын шинжлэх ухааны онолын баримтлалуудыг удирдлагын практикт хөрвүүлэх хэл нь болдог. Өөрөөр хэлбэл, удирдлагын онол болон практикийн холбоо нь удирдах үйл ажиллагааны зарчмуудыг боловсруулах аргаар хэрэгжиж байдаг. Удирдлагын зарчмуудад нөлөөллийн байгууламж, нөлөөлөл үзүүлэх арга хэлбэр, удирдлагын субъект болон объектын харилцан ажиллагааны шинж чанарыг тусгаж өгдөг.

Удирдлагын үндсэн зарчмууд

1.Тодорхой зорилго

Байгууллагын зорилго, зорилтууд нь тодорхой, хэмжигдэхүйц, хүрч болохуйц, холбогдох, хугацаатай байх ёстой.

2.Хариуцлага

Байгууллагын бүх гишүүд өөрсдийн үүрэг хариуцлагаа хүлээж, ажлаа цаг тухайд нь, чанартай гүйцэтгэх ёстой.

3. Хяналт

Байгууллагын бүх гишүүд өөрсдийн үүрэг хариуцлагаа хүлээж, ажлаа цаг тухайд нь, чанартай гүйцэтгэх ёстой.

4.Уян хатан байдал

Байгууллага нь өөрчлөлтөд дасан зохицох чадвартай, хурдан хариу үйлдэл үзүүлж чаддаг байх ёстой.

ДҮГНЭЛТ

Удирдлагыг зохион байгуулах удирдагч /захирагч/ нь өмнөө тавьсан

зорилго, зорилтод хүрэхийн тулд бие бүрэлдэхүүний итгэлтэй хамтач ажиллагааг урьдал болгож, өөрийн хэрсүү ухаан, зангилаа, асуудалд анхаарал төвлөрүүлэх мадаггүй ойлголтод хүрэх чадвараа нэмэгдүүлж, дайн, байлдааны үндсэн шинж чанараас үүдэлтэй тодорхойгүй, нийгэмлэхийн төлөө тэмцэж ажиллах нь чухал юм.

Цэргийн удирдлага гэх нэр томъёоны цэргийн гэдэг тодотгол нь дайн ба армийн тухай ойголтыг бүхэлд нь хамаарч дайн ба армитай холбоотой бүхнийг тодорхойлж байдаг. Энэ үүднээс цэргийн удирдлага нь хүн төрөлхтний үйл ажиллагааны бусад хүрээний удирдлагаас ялгагдах шинж чанартай юм.

Нийгэмдэх хүмүүсийн зохион байгуулалтын үндсэн үүрэг нь бие хүний үйл ажиллагааг нийгмийн төрөл бүрийн салбарын үйл ажиллагаатай уялдуулан зохицуулж нийгмийн удирдлагын тухайн чиглэсэн үйлчлэлийн дор нэгтгэхэд оршдог бол цэргийн удирдлага нь улс орны аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах, зэвсэгт тэмцлийн үүргийг биелүүлэх зорилгоор төрийн хүчирхийллийн аргаар хүмүүсийг нэгтгэн байгуулсан онцгой хэлбэртэй төрийн цэргийн байгууллагуудын удирдлага юм.

НОМ ЗҮЙ

Ашигласан ном, зохиол, эх сурвалж:

1. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 2010 он, УБ;

2. Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, 2001 он, УБ;

3. УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” бодлого

4. Б.Түмэн, Байлдааны нөхцөлд ерөнхий цэргийн штабуудын алба, 2003 он, УБ;

5. Д.Доржготов, Цэргийн стратегийн үндэс, 2008 он, УБ;

6. Ц.Дашзэвэг, Цэргийн удирдлагын үндэс, 2003 он, УБ;

7. Ч.Улаанхүү, Цэргийн удирдлага, 2005 он, УБ;

8. Ч.Жүгдэр, Чингисийн төрийн үзэл, цэргийн урлаг, 1991 он, УБ;

9. Б.Түмэн, Цэргийн урлагийн түүх, 2005 он, УБ;

10. Ч.Улаанхүү, Цэргийн урлагийн тухай, 2003 он, УБ;

11. Х.Шагдар, “Чингисийн байлдааны цадиг”, 1993 он, УБ;

12. Мэдээллийн сайт:

<http://gsmaf.gov.mn/>

<http://udirdahui.blog.gogo.mn/>

www.naog.gov.mn/